



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар ХХ/3127

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хийж буй ажлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: 6 хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021517096

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛЭЭС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

### Асуулга 1.Түгжрэлийг бууруулах чиглэлээр өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлууд, тэдгээрийн үр дүнгийн талаар

Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо нь түгжрэл бууруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

1.Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэр, шилжилт хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдлыг судлах чиглэлээр Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны статистик мэдээлэл, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын энэ чиглэлээр хийж хэрэгжүүлсэн судалгааны тайлан зэрэг холбогдох материалыг цуглуулж, баримтын шинжилгээ хийсэн. Баримтын шинжилгээгээр одоогийн нөхцөл байдлыг нарийвчлан ойлгож, шилжилт хөдөлгөөний суурь шалтгааныг тодорхойлсон.

2.Төвлөрлийг сааруулах арга хэмжээний санал боловсруулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулан, холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн төлөөлөл, эрдэмтэн судлаачидтай 30 гаруй удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

3.Төвлөрлийг сааруулах арга хэмжээний саналыг Улаанбаатар хот, 21 аймгийн 3,000 иргэн, 300 аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтнаар үнэлгээ хийлгэж, эдгээр арга хэмжээнээс хамгийн үр дүнтэй арга хэмжээг тодорхойлсон.

Үндэсний хорооны ажлын алба нь авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр доорх ажлуудыг судлан, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулан ажилласан. Үүнд:

-Иргэдийн зорчилт хөдөлгөөний одоогийн болон хэтийн судалгаа, Нийслэл Улаанбаатар хотын цаашдын төлөвлөлтийн судалгаа, шинээр барих авто замын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн судалгаа зэргийг хийж гүйцэтгэсний үндсэн дээр нэн тэргүүнд барих шаардлага бүхий гол болон туслах гудамж замуудыг тодорхойлсон;

-Түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний газар чөлөөлөлтийн нэгж талбарыг тодорхойлсон;

-Замын геометр болон хөдөлгөөн зохион байгуулалтын алдаатай төлөвлөлтөөс шалтгаалан түгжрэл үүсэхэд нөлөө үзүүлж буй уулзваруудыг судалсны үндсэн дээр дахин инженерчлэл хийх шаардлагатай уулзваруудыг тодорхойлсон;

-Авто зогсоол шинээр барих, шинэчлэх, менежментийг сайжруулах ажлын хүрээнд эрэлт нийлүүлэлтийн судалгаан дээр үндэслэн авто зогсоолын хэрэгцээг тодорхойлон дахин зохион байгуулах төлөвлөлт боловсруулсан;

-Замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын ухаалаг систем (RFID) нэвтрүүлэх чиглэлээр судалгаа хийн, холбогдох байгууллагуудтай санал зөвшилцсөн;

-Иргэдийн зорчих эрэлт хэрэгцээ, олон улсын туршлага зэрэг дээр үндэслэн Нийслэл Улаанбаатар хотын нөхцөлд тохирох их багтаамжийн нийтийн тээврийн системийг тодорхойлох судалгааг хийсэн;

-Сургууль, цэцэрлэгийн хүртээмж багатай байршлыг судлан, нэн тэргүүнд барьж ашиглалтад оруулах шаардлага бүхий байршлыг тодорхойлсон.

## **Асуулга 2.Түгжрэлийн өнөөгийн нөхцөл байдал, түүний улмаас үүсч буй хохирол, алдагдсан боломжуудын талаар**

Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар нийт 1,136,734 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагийн 54.2 хувь буюу 615,622 нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Эдгээр тээврийн хэрэгслээс 62.3 хувь нь буюу 383,703 орчим автомашин өдөр тутам замын хөдөлгөөнд идэвхтэй оролцдог.

Улаанбаатар хотын авто замын сүлжээний даац 2010 онд 238 600, 2020 онд 283 925 болж 18% өссөн бол тээврийн хэрэгсэл 2010 онд 234 108, 2020 онд 604 818 болж 2,5 дахин өссөн.

Нийслэл хотын авто замын сүлжээн дэх хатуу хучилттай замын урт 1,156 км байгаа бөгөөд зонхилох хэсэг 75 орчим хувь нь хотын барилгажсан хэсгийн нутаг дэвсгэрт төвлөрч, хатуу хучилттай авто замын хүртээмж муу байдгаас замын хөдөлгөөний түгжрэл үүсгэдэг. Хэвтээ тэнхлэгийн дагуу хотын баруун, зүүн хэсгийг шууд холбосон гол замууд дутагдалтай тул хэвтээ тэнхлэгийн дагуу Энхтайвны өргөн чөлөөнд ирэх замын хөдөлгөөний ачаалал ихтэй, хотын босоо тэнхлэгийн дагуу Туул гол дээгүүрх гүүр дутмагаас хотын замын хөдөлгөөний урсгалыг саадгүй шууд нэвтрүүлэх боломжийг хязгаарладаг. Гэр хорооллын доторх ердийн хөрсөн зам нь хотын замын сүлжээнд хамрагдахгүйгээс гадна орчны бохирдол үүсгэх үндсэн нөхцөл болж байна.

Дээрх нөхцөл байдлаас гадна гол гудамж замын хөдөлгөөний эрчим, авто замын багтаамжийн харьцаа  $VCR = 1.3 - 2.09$  бол туслах гудамж замын хөдөлгөөний эрчим, авто замын багтаамжийн харьцаа  $VCR = 0.82 - 1,36$  байна. Хөдөлгөөний чанарын үзүүлэлт LOS "F" түвшин байна. Харин авто замын оргил цагийн хөдөлгөөний дундаж хурд 9-13 км/ц байгаа нь хотын гудамж замын уулзварууд хурдацтай өсөн нэмэгдэж буй тээврийн хэрэгслийн ачааллыг даах чадваргүй болсон төдийгүй ихэнх уулзварууд гэрлэн дохиоллын зохицуулалтгүй, зарим уулзварууд нь зөв бус хэлбэртэй, хөдөлгөөн зохион байгуулалтын оновчтой төлөвлөлтгүй хийгдсэн байх тул хөдөлгөөний ачааллыг нэмэгдүүлж, нэвтрүүлэх чадварыг эрс бууруулдаг.

Мөн гудамж замын зам барилгын ажилд ашиглагдаж буй материал, түүхий эдийн чанар стандартын шаардлага бүрэн хангадаггүй, ажлын гүйцэтгэлийн чанар хангалтгүй, даац хэтэрсэн тээврийн хэрэгслээр зорчих, засвар арчлалт, хамгаалалтын ажил тогтоогдсон хугацаа, графикийн дагуу бүрэн гүйцэд хийгддэггүй эсхүл зарцуулах төсөв хөрөнгө хүрэлцдэггүй зэрэг нь авто замын түгжрэлийн шалтгаануудын нэг

болдог.

Нийтийн тээврийн үйлчилгээнд 2020 оны байдлаар нийслэлийн өмчийн 2, хувийн хэвшлийн 17 аж ахуйн нэгж 99 чиглэлд 943 их багтаамжийн автобус, троллейбусоор өдөрт 500-600 мянган зорчигч тээвэрлэж байна. Нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн чиглэлд данс бүртгэлээр 1217 тээврийн хэрэгсэл байгаа бөгөөд дундаж насжилт 9,5 жил байна. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага “MNS 5012:2011” стандартын дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд үйлдвэрлэгдсэнээс хойш 12 жил ашиглагдсан тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглодог бөгөөд 2021 онд 531 автобус, 2022 онд 121 автобус, 2023 онд 151 автобус, 2024 онд 60 автобус ашиглалтын хугацаагаар үйлчилгээнээс хасагдахаар байна.

Нийтийн тээврийн хэрэгслийн дундаж хурд 15 км/цаг байдаг бол хотын төвийн хэсэгт 6-8 км/цаг хүртэл буурч нийтийн тээврийн хүртээмж хүрэлцээ тааруу байгаагаас нийтийн тээврээр зорчигч нарын тоо багасах хандлагатай байна.

Гудамж замын дагуух дугуйн зам, явган зам нь зорчигчийн аюулгүй байдлыг хангасан, бат бэх, тогтвортой, халтиргаа, гулгаанаас хамгаалсан, борооны ус зайлуулах худагтай, ая тухыг хангасан, тээврийн хэрэгслийн нэг төрлөөс нөгөө төрөлд дамжин суух богино хугацааны зорчилт хийх нөхцөлийг бүрдүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саадгүй, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн, хүрэх газраа очих хүртэл гэрэлтүүлэг, ногоон байгууламж, амрах талбай, хогийн сав бүхий тохижилттой байх ёстой. Гэтэл явган болон дугуйн замын хүртээмж муу, тохижилт хангалтгүй, чанар, өнгө үзэмж муутай, амархан эвдэрч гэмтдэг, хийц болон түүхий эд материалууд нь стандартын шаардлага хангадаггүй, явган зам хэтэрхий нарийн, дээр доор нэг түвшний бус баригддаг, явган зам нь дугуйн зам, авто замын хоёрын дунд баригдсан, явган зам дээр аж ахуйн нэгж байгууллагууд кадастрын зургаа хэтрүүлэн орох-гарах гарц, хашаа, шат барьсан, автомашин зогсоолгодог, нарийн авто зам дээр явган зам руу дугуйгаа тэгнүүлэн автомашин зорчдог, үйлчилгээний байгууллагад зориулсан явган хүний зам болон барилга байгууламжийг тусгаарласан явган хүний зорчих чөлөөний хэсэг байхгүй зэрэг олон сөрөг нөхцөл байдалтай байна.

Иргэд хотын түгжрэлд өдөрт дунджаар 2.5 цаг, жилд 35 өдрийг өнгөрүүлдэг бөгөөд түгжрэлээс болж алдсан боломжийн нийт өртөг жилд 2.7 их наяд төгрөг түгжрэлд алдаж байгаа нь нийт бүтээж буй баялгийнхаа 8%-г алддаг, энэ байдал хэвээр үргэлжилбэл 2025 он гэхэд энэ тоо 24 их наяд болох тооцоо гарсан.

### **Асуулга 3.Түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, шийдэл болон хийхээр төлөвлөсөн ажлуудын талаар**

Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны ажлын хүрээнд “Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах” 3 зорилго, 27 зорилт, 149 арга хэмжээ бүхий хөтөлбөр боловсруулагдсан.

Энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго нь нийслэл Улаанбаатар хотын авто замын хэт их ачааллыг бууруулах, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, хотын төвлөрлийг сааруулахад тулгамдаж буй суурь асуудлуудыг шийдвэрлэх, хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжин, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах замаар

Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулах, олон төвт хотын загварт шилжих, дагуул хот болон дэд төвүүдийг хөгжүүлэх, хотын иргэдийн аюулгүй, эрүүл, тав тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн хот болгон хөгжүүлэхэд чиглэсэн болно.

Хотын түгжрэлийг авто замын сүлжээг тэлэх, замын байгууламжийг нэмэх, засан сайжруулах, уулзвар шинэчлэх, гарцыг нэмэгдүүлэх болон хот төлөвлөлт, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг зөв зохион байгуулж цогц тогтолцоогоор нь шийдвэрлэхэд оршино. Иймд энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах үндсэн Гурван зорилгыг чиглэл болгож, нийт 27 зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнд:

### **ЗОРИЛГО 1.Хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангахад тулгамдаж буй суурь асуудлуудыг шийдвэрлэнэ.**

Орон нутагт болон дагуул хаяа хотуудад үйлдвэрлэл, жижиг, дунд бизнес, нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлэх, их дээд сургуулиудыг хотоос нүүлгэх замаар хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасган хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дэмжиж Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хотын хэт төвлөрлийг сааруулах замаар хотын түгжрэлийг бууруулна. Энэхүү зорилгын хүрээнд 5 үндсэн зорилт, 26 төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зорилт 1.1.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бодлогын хэрэгжилтэд анхаарч, хүн амын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, газар олголт, суурьшлын бүсийн тэлэлтэд хяналт тавьж, хүн амын тав тухтай амьдрах орчинг сайжруулахад чиглэнэ.

Зорилт 1.2.Бүсчилсэн хөгжлийн бодлогыг Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг дэмжиж ялангуяа орон нутгийн удирдлага, санхүү төсөв, хөрөнгө оруулалтын бодлогыг нарийвчлан судалж, тэргүүлэх ач холбогдол бүхий хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон хөрөнгө оруулалтын зардлыг тусгах, эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгоно.

Зорилт 1.3.Орон нутгийн хөгжлийн бодлогыг дэмжиж, орон нутаг тогтвор суурьшилтай үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон шинээр бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, дэд бүтцээр хангах, татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг хялбаршуулах замаар чирэгдэлгүй үйлчилгээг нэвтрүүлэхэд чиглэнэ.

Зорилт 1.4.Орон нутагт иргэдийн тав тухтай амьдрах таатай орчинг бүрдүүлэх нийгмийн дэд бүтцийг бүрдүүлэх, орон сууцжуулах, ялангуяа төрийн албан хаагчдын цалингийн түвшин, сүлжээг сайжруулах замаар тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулахад анхаарч төрийн удирдлагын залгамж холбоог бэхжүүлэх, орон нутгийн нийгмийн хөгжлийг дэмжинэ.

Зорилт 1.5.Хөгжлийн ирээдүйтэй суурин газрыг тодорхойлж, түүнд худалдаа, ложистикийн төвүүдийг байгуулж, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжинэ.

## **ЗОРИЛГО 2.Улаанбаатар хотын “нэг төвт, шугаман хот”-ын төрхийг задалж, “олон төвт хот”-ын загварт шилжин хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн суурь асуудлыг шийдвэрлэнэ.**

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт барилгажилтын нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тогтоож, эмх замбараагүй тэлэлтийг зогсоох арга хэмжээний хүрээнд хилийн цэсийг тогтоож, хотын зүй бус төвлөрлийг задалж, хотын дэд төвүүд, хаяа, дагуул хот, тосгонуудыг хөгжүүлэх, хотын төв рүү чиглэсэн зорчилтын зорилго, чиглэлийн давхцалыг багасгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулна. Энэхүү зорилгын хүрээнд 4 үндсэн зорилт, 15 арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

Зорилт 2.1.Төрийн захиргааны зарим чиг үүргүүд болон төрийн үйлчилгээний байгууллагыг дагуул хотуудад чиглүүлнэ.

Зорилт 2.2.Дагуул хот тосгон, дэд төв, Улаанбаатар хотын бүсчлэлийн эдийн засгийн хөгжлийн кластерын зураглалыг боловсруулж, эдийн засгийн гол төслүүдийг хэрэгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг дэмжих бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх хөрөнгө оруулалт, татварын бодлогын арга хэмжээг зохион байгуулна.

Зорилт 2.3.Дагуул хот тосгон, дэд төв, Улаанбаатар хотын бүсчлэлд нийгмийн дэд бүтцийг хөгжүүлж, “сайн сургууль”, “сайн цэцэрлэг”, “сайхан орон сууц”, “зөв боловсон амралт” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж иргэдийн тав тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.

Зорилт 2.4.Дагуул хот тосгон, дэд төв, Улаанбаатар хотын бүсчлэлд инженерийн дэд бүтцийн хангамж, ногоон байгууламж хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.

## **ЗОРИЛГО 3.Улаанбаатар хотын авто замын хэт их ачааллыг бууруулах**

Улаанбаатар хотын түгжрэлийн асуудлыг шийдвэрлэхэд авто замын сүлжээг тэлэх, замын байгууламжийг нэмэх, засан сайжруулах, уулзвар сайжруулах, гарцыг нэмэгдүүлэх, дугуйн болон явган замын сүлжээг тэлэх, Нийтийн тээврийн тогтолцоог шинэчлэн сайжруулах, багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийг нэвтрүүлэх, замын хөдөлгөөн зохицуулалтын ухаалаг систем нэвтрүүлэх, хөдөлгөөний урсгал, ачааллын талаар бодит мэдээллээр хангагдах “хөтөч” /Navigation/ -ийг бий болгох, теле хяналтын камераар иж бүрэн хянах, замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг сайжруулах, хөдөлгөөнд оролцох иргэдийн соёл боловсролыг дээшлүүлэх, зам тээврийн ослын дуудлага, мэдээллийг шуурхай шийдвэрлэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгож иргэд автомашины камер /хар хайрцаг/-ын тусламжтай зөрчлийг илрүүлэх, хэрэг маргааныг шийдвэрлүүлэх, барилга байгууламж, зогсоол төлөвлөх гэх мэт инженерийн зураг, төсөл боловсруулах явцад талуудын оролцоо, хяналт тавих болон тэдгээрийг зохицуулах зөөлөн бодлого эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Энэхүү зорилго 18 үндсэн зорилт, 108 төсөл арга хэмжээнээс бүрдэнэ.

Зорилт 3.1.Авто машины эрэлт нийлүүлэлтийг зохицуулах;

Зорилт 3.2.Тээврийн хэрэгслийн зорчилтын эрэлтийг зохицуулах;

- Зорилт 3.3.Зогсоолын төлбөр хураамжийн тогтолцоог боловсронгуй болгох ба холбогдох арга хэмжээг цогцоор шийдвэрлэх;
- Зорилт 3.4.Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг сайжруулах;
- Зорилт 3.5.Замын засвар арчлалтын тогтолцоог цогц байдлаар шийдвэрлэх;
- Зорилт 3.6.Улаанбаатар хотын гол гудам, замын сүлжээг нэмэгдүүлэх;
- Зорилт 3.7.Хороолол дундах холбоос замын сүлжээг нэмэгдүүлэх;
- Зорилт 3.8.Улаанбаатар хотын тойрог авто замын сүлжээг хөгжүүлэх;
- Зорилт 3.9.Улаанбаатар хотын дугуйн замын сүлжээг хөгжүүлэх;
- Зорилт 3.10.Улаанбаатар хотын явган замын сүлжээг хөгжүүлэх;
- Зорилт 3.11.Авто замын сүлжээн дахь нүхэн гарц байгуулах;
- Зорилт 3.12.Авто замын сүлжээн дахь зарим уулзварыг дахин инженерчилж, нэвтрүүлэх чадварыг сайжруулах;
- Зорилт 3.13.Нийслэлийн гудамж, замын орон зайн мэдээллийн санг хөгжүүлэх;
- Зорилт 3.14.Замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын ухаалаг систем нэвтрүүлэх;
- Зорилт 3.15.Авто зогсоолын төлөвлөлт, ашиглалтыг сайжруулах;
- Зорилт 3.16.Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн их багтаамжийн нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх;
- Зорилт 3.17.Автобус тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг шинэчлэн сайжруулах;
- Зорилт 3.18.Дүүжин тээврийн үйлчилгээг нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр өргөн барьсан Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх цогц арга хэмжээнд зориулж 420 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт тусгасан бөгөөд төслийг Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Мөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар нийслэлийн төсвийг баталсан бөгөөд дээр дурдсан гурван зорилго, 27 зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, зохион байгуулах нөхцөл бүрдээд байна.

-----oO-----